



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ

ДЭД САЙД С.НАРАНЦОГТ


2022.10.19

АГУУЛГА

- I. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал
- II. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан төсвийн төсөл

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭ ТОГТВОРТОЙ ДЭМЖИЖ БАЙГАА БОЛ ЭКСПОРТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХЭЛБЭЛЗЛИЙН ГОЛ ШАЛТГААН БОЛЖ БАЙНА.


БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТИЙН БҮТЭЦ (ХУВЬ)



- **Эдийн засгийн өсөлтийн хувь хэлбэлзэх интервал өндөр байна.** ДНБ-ий жилийн бодит өсөлт сүүлийн арав орчим жилд хамгийн өндөртөө 17.4 хувь хүрсэн бол хамгийн багадаа -4.4 хувь хүрсэн байна. Цар тахлаас өмнө хамгийн багадаа 1.5 хувь байсан.
- 2022 оны эхний хагас жилд нийт эрэлт 1.9 хувиар өслөө. Өсөлтийг машин тоног төхөөрөмжийн хуримтлал, үйлчилгээний импортын өсөлт голлон дэмжсэн бол барааны экспортын бууралт эрэлтийг хязгаарласан байна.


ЭКСПОРТ ЭМЗЭГ, ИМПОРТЫН ХЭРЭГЛЭЭ ӨНДӨР БАЙНА.

ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭНИЙ БУУРАЛТ




Экспортын хилийн боомтууд дахь нэвтрэлт саатсанаар экспортын биет хэмжээ тогтворгүй байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭНЦЛИЙН АЛДАГДАЛ ӨНДӨР



Дэлхий дахинд үнийн өсөлт эрчимжиж байгаа нь импортоор дамжин манай улсын төлбөрийн тэнцлийн алдагдлыг нэмэгдүүлж байна.


ХЭРЭГЛЭЭНИЙ БАРААНЫ ИМПОРТЫН ӨСӨЛТ



Хэрэглээний барааны импорт нийт импортын **31 орчим хувьтай** тэнцэж байна.

ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ ЭРЧИМТЭЙ БУУРЧ БАЙНА.


ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ГВАН (сая ам.доллар)



ГВАН 8 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 2.4 тэрбум ам.доллар.

2022 оны эхний 8 сард нийт 3,914 сая ам.долларыг зах зээлд нийлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс **1.9 дахин**, 2019 оны мөн үеэс **2.3 дахин их** дүн байна.


ГВАН ХҮРЭЛЦЭЭТ ТҮВШИН (сарын импортоор)



Жишиг түвшин 3 сараас дээш. Сүүлийн 3 сарын импортын дунджаар тооцов.

9 дугаар сарын эцсийн байдлаар ГВАН 2.7 тэрбум ам.долларт хүрч, **барааны импортын 3.3 сарын хэрэгцээг хангах** түвшинд байна.

ГВАН ХҮРЭЛЦЭЭТ ТҮВШИН (ага хэмжүүрээр)




Жишиг түвшин 100-гаас дээш.



БОДИТ ХЭРЭГЦЭЭНЭЭС ДАВСАН МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ ХИЙГДСЭН.


ТӨСВИЙН ШИНЖТЭЙ МӨНГӨНИЙ ӨСӨЛТ



(Өссөн дүнгээр)

Монголбанкнаас сүүлийн 10 жилийн хугацаанд **төсвийн шинжтэй 9.1 их наяд төгрөгийн мөнгөний нийлүүлэлт хийгдсэн** байна.

ХУДАЛДАА, ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖСЭН ЗЭЭЛИЙН БҮТЭЦ



Улирлаар

Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2022 оны 8 дугаар сарын байдлаар **22.6 их наяд төгрөгт** хүрч, өмнөх оны мөн үеэс **14.6 хувиар өссөн** байна. Өсөлтийн дийлэнхийг худалдаа, хэрэглээний зээл бүрдүүлсэн байна.

ТӨГРӨГИЙН ХАНШИЙН СУЛРАЛТ



Төгрөгийн ханш 3,360 төгрөг болж, оны эхнээс **510 төгрөгөөр буюу 18 хувиар** сулраад байна.


(2022.10.07-ны өдрийн байдлаар)

Арилжааны банкны ханшийг Голомт, ХХБ, Хаан банкнуудын бэлэн зарах ханшийн дунджаар, Найман шаргын ханшийг Уран уургач, Евро Ази байгууллагуудын дунджаар авав.


ӨРХИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ ЭМЗЭГ БОЛЖ БАЙНА.

ӨРХИЙН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН ЖИЛИЙН ӨСӨЛТ


Улсын




Нийслэл




Аймгийн төв



Сумын төв



Хөдөө



- Өрхийн нийт орлого дахь тэтгэвэр, тэтгэмжийн орлогын жин нэмэгдсэн.


- 2018-2020 он 20 хувь
- 2021 он 30 хувь

- Цаашид цар тахлын өмнөх үндсэн орлогын эх үүсвэр нь сэргэж байгаа бүлгүүдийн дэмжлэгийг үе шаттай бууруулах.

Сумын төв, хөдөөд амьдардаг өрхүүдийн МАА-н үйлдвэрлэлийн орлого сэргэж байна.

- Ажил эрхлэлтийг эрчимтэй дэмжих замаар цалингийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

ЭНЭ УДААГИЙН ХЯМРАЛ НЬ ИЛҮҮ ГҮНЗГИЙ БӨГӨӨД УДААН ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, ҮСХ-ны статистик

- Эдийн засгийн нийт үйлдвэрлэл (ДНБ) нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар боломжит хүчин чадлаасаа **3.9 хувиар бага** байна.
- COVID-19-ын үеийн хямрал нь өмнөх хямралуудаас **удаан** үргэлжилж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ГШХО, ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭЭС ИХЭЭХЭН ХАМААРЧ БАЙНА.

ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛБЭЛЗЛИЙН ШАЛТГААН, 2020



ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛБЭЛЗЛИЙН 40 ГАРУЙ ХУВЬ ГШХО, ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭЭС ШАЛТГААЛЖ БАЙНА.

Эх сурвалж: Уул уурхай ба оюун ухаан, Дэлхийн банк, 2020 он

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨСӨЛТ БОЛОН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРОХ УРСГАЛ



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ УУЛ УУРХАЙН САЛБАРААС ХАМААРАЛТАЙ.



Эх сурвалж: Олон улсын валютын сан

ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН ТӨРӨЛЖӨӨГҮЙ, НЭГ УЛСААС ХАРААТ БАЙНА.

ЭКСПОРТЫН БҮТЭЦ, 2021



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ТОП 3 экспортлогч орон:

- Хятад-88.9%
- Швейцар-6.35%
- Итали-0.59%

Нийт экспортын
хэмжээ
8.3 тэрбум
ам.доллар

Экспортын
хэмжээгээр
дэлхийн 133
орноос **101**-т
жагсаж байна.

Монгол Улсын
эдийн засгийн
цогц байдлын
индекс:

-1.96


Эдийн засгийн
цогц байдлын
индексээрээ
дэлхийн 133
орноос **113**-т
жагсаж байна.

Сүүлийн 10
жилд
9 байраар
ухарсан.



НИЙТ ЭКСПОРТОД НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭЭГҮЙ БАРАА ЗОНХИЛДОГ НЬ ӨРСӨЛДӨХ ЧАДВАР СУЛ БАЙГАА ГОЛ ШАЛТГААНЫ НЭГ ЮМ.

ЭКСПОРТЫН ТӨРӨЛЖИЛТИЙН ИНДЕКС, БАЙР



Эх сурвалж: Atlas of economic complexity

ЭКСПОРТЫН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ЦӨӨН

Сүүлийн 15 жилийн хугацаанд Монгол улс зөвхөн **6 шинэ төрөл зүйлийн** бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлсэн:

- | | |
|-----------------------|---------------------------------|
| 1. Цайрын хүдэр | 1. Хадгалсан мах |
| 2. Хар тугалгын хүдэр | 2. Тосны ургамлын үр (Рапс) |
| 3. Лаазалсан мах | 3. Ноосоор хийсэн нэхмэл даавуу |

СҮҮЛИЙН 15 ЖИЛД ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ТҮҮНИЙ НЭГ ХҮНД НОГДОХ ЭКСПОРТЫН ДҮН

Улс орнууд	Шинэ бүтээгдэхүүн	Нэг хүнд ногдох экспорт	Нийт экспорт
БНХАУ	43	\$ 74	\$ 103 тэрбум
Казакстан	19	\$ 48	\$ 886 сая
Бангладеш	12	\$ 1	\$ 172 сая
Монгол	6	\$ 67	\$ 217 сая

Эх сурвалж: Atlas of economic complexity

Төрөлжилтийн түвшнээрээ дэлхийн 133 орноос **117-д** жагсаж байна.

Сүүлийн 15 жилд **17** байр ухарсан.



АГУУЛГА

- I. Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал
- II. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан төсвийн төсөл

БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИНЭ ТОГТОЛЦОО БҮРДЭЖ БАЙНА.



ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ
ҮНЭТ ЗҮЙЛ



ХҮНИЙ
ХӨГЖИЛ



АМЬДРАЛЫН ЧАНАР БА
ДУНДАЖ ДАВХАРГА



ЭДИЙН
ЗАСАГ



САЙН
ЗАСАГЛАЛ



НОГООН
ХӨГЖИЛ



АМАР ТАЙВАН,
АЮУЛГҮЙ НИЙГЭМ



БҮСЧИЛСЭН
ХӨГЖИЛ



УЛААНБААТАР БА
ДАГУУЛ ХОТ

ДУНД ХУГАЦААНД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, САНХҮҮГИЙН САЛБАРЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ
ХӨТӨЛБӨРийн төсөлд:



ҮНДЭСНИЙ
ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ
ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР



Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

Эдийн засгийн
жилийн дундаж
өсөлт

2021 он

1.4

хувь

2030 он

6

хувь

Инфляцын
түвшин

2021 он

13.4

хувь

2030 он

6

хувь

Зорилт 1.1. Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж,
Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангана.

- Төсвийн төлөвлөлт, санхүүгийн удирдлагыг сайжруулах
- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, үр ашгийг нэмэгдүүлэх
- ЗГ-ын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулах
- Баялгийн сангийн менежментийг сайжруулах

Төсвийн
тэнцвэржүүлсэн
тэнцлийн ДНБ-д
эзлэх хэмжээ

2021 он

6.8

хувь

2030 он

0

хувь

Санхүүгийн
салбарын нийт
активын ДНБ-д
эзлэх хэмжээ

2021 он

24

хувь

2030 он

40

хувь

Зорилт 1.2. Санхүүгийн салбарыг өргөжүүлж,
эрсдэл даах байдлыг сайжруулна.

- СЗЗ-д оролцогчид, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх
- СЗЗ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх

ДУНД ХУГАЦААНД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, САНХҮҮГИЙН САЛБАРЫГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.

ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ
ХӨТӨЛБӨРийн төсөлд:



ҮНДЭСНИЙ
ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫГ
НЭМЭГДҮҮЛЭХ
ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР



Эдийн засгийг төрөлжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

**Боловсруулах аж үйлдвэрийн
салбарын ДНБ-д эзлэх хувь**

2021 он

9.0

ХУВЬ



2030 он

14.6

ХУВЬ

Зорилт 3.1. Тэргүүлэх салбаруудын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх
- Түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх
- Шинэ бүтээгдэхүүн, салбаруудыг нэмэгдүүлэх
- Бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын салбарын өрсөлдөхүйц байдал, үр ашгийг нэмэгдүүлэх
- Үндэсний брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх

**Хөдөлмөрийн
бүтээмжийн түвшин -
улсын түвшинд (2015
оны зэрэгцүүлэх**

2021 он

22.5

сая төгрөг



2030 он

29.

3

Зорилт 3.2. Дэд бүтцийн чанар, үр ашгийг сайжруулна.

- Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын үр ашгийг нэмэгдүүлэх
- Тээвэр, логистикийн аюулгүй байдал, хяналт үйлчилгээний чанарын шаардлагыг хангах

**Логистикийн
гүйцэтгэлийн
индекс**

2021 он

2.4



2030 он

3.0



ТӨЛӨВЛӨЛТӨД СУУРИЛСАН ТӨСӨВЛӨЛТ ЗАРЧИМ БАРИМТАЛЖ БАЙНА.

Улсын хөгжлийн жилийн
төлөвлөгөөний төсөлд хүргүүлэх
саналаа

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
ЯАМАНД ХҮРГҮҮЛНЭ

2022.01.1
5

Улсын хөгжлийн жилийн
төлөвлөгөөний төслийг

ЗАСГИЙН ГАЗАРТ
ТАНИЛЦУУЛНА

2022.03.2
5

Засгийн газар Улсын
хөгжлийн жилийн
төлөвлөгөөний төслийг
УЛСЫН ИХ ХУРАЛД
ӨРГӨН МЭДҮҮЛНЭ

2022.05.0
1

Улсын хөгжлийн жилийн
төлөвлөгөөг

УЛСЫН ИХ ХУРАЛ
ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛНА

2022.06.0
1

2022.11.1
5

Тухайн жилийн төсвийг

2022.10.0
1

Засгийн газар Төсвийн
төслийг

2022.09.15

Төсвийн төслийг

2022.08.15

Төсвийн төсөлд
хүргүүлэх саналаа

УЛСЫН ИХ ХУРАЛ
ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛНА

УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН
МЭДҮҮЛНЭ

ЗАСГИЙН ГАЗАРТ ӨРГӨН
МЭДҮҮЛНЭ

САНГИЙН ЯАМАНД
ХҮРГҮҮЛНЭ

УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

- Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг арилгахад чиглэсэн байх
- Эдийн засгийн суурийг тэлж, орлого нэмэгдүүлэх том төслүүдийг хэрэгжүүлэх
- Ковид-19 цар тахлын сөрөг үр дагаврыг бууруулах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих
- Одоо байгаа нөөц, боломжтой уялдуулж, 2023 онд шинээр эхлэх төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх
- Хуульд заасан шаардлагыг баримталж, бэлэн байдал хангагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх



УХЖТ-НД ТУССАН, УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ЗЭЭЛ ТУСЛАМЖААР САНХҮҮЖИХ НИЙТ 155 АРГА ХЭМЖЭЭНИЙ 139 НЬ ТӨСӨВТ ТУСГАГДСАН БАЙНА.

5

БҮЛЭГ



ХҮНИЙ
ХӨГЖЛИЙН
БОДЛОГО



ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГО



ИРГЭН ТӨВТЭЙ
ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН
ЗАСАГЛАЛЫН
БОДЛОГО



НОГООН ХӨГЖИЛ,
БАЙГАЛЬ ОРЧНЫ
ТЭНЦВЭРТЭЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ
БОДЛОГО



НИЙСЛЭЛ БА БҮС,
ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН
БОДЛОГО

201

АРГА ХЭМЖЭЭ

54

АРГА ХЭМЖЭЭ

79

АРГА ХЭМЖЭЭ

21

АРГА ХЭМЖЭЭ

11

АРГА ХЭМЖЭЭ

36

АРГА ХЭМЖЭЭ

Онцлох
ажлууд

- Боловсролын чанар, хүртээмж
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоо
- Халамжаас хөдөлмөрт Тэтгэврийн шинэчлэл

- Эдийн засгийн тогтвортой байдал
- Боомт, Эрчим хүч, Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хөгжлийн төслүүд
- Тэргүүлэх салбарууд /Уул уурхай, ХАА, аялал жуулчлал/

- Төрийн албан хаагчийн цалингийн тогтолцооны шинэчлэл
- Цахим засаглал

- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах

- Хөшгийн хөндийн бүтээн байгуулалт
- Орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх

Төсөвтэй
уялдсан
байдал

78.7

УЯЛДАА

95.7

УЯЛДАА

90.5

УЯЛДАА

88.8

УЯЛДАА

93.3

УЯЛДАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 23

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг баталсантай холбогдуулан тус төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, цаашид улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:
 - 1/Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгасан улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;
 - 2/Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд төр, хувийн хэвшлийн түншлэл болон зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгасан төсөл, арга хэмжээнд шаардагдах бэлтгэл хангаж ажиллах;
 - 3/улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхойлж, хөгжлийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн тусгах, түүнчлэн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт бүрийн хэрэгжилтийг үнэлэх боломжтойгоор төлөвлөгөөний төслийг боловсруулах;
 - 4/хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах, түүнд санал ирүүлэх, хэрэгжилтийг үнэлэх талаар салбар, орон нутгийн хэмжээнд холбогдох байгууллага, албан тушаалтныг нэгдсэн арга зүй, удирдамжаар хангаж ажиллах.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд даалгасугай.
4. Энэ тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР

2022 ОНД ЭХЛҮҮЛЖ, 2023 ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД БОДИТОЙ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛ ХЭРЭГ БОЛГОХ, УЛМААР ҮР НӨЛӨӨ НЬ 2023 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТЭД ЭЕРЭГ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

- Төсөв, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эдийн засгийг тогтворжуулах
- Валютын бодит мөнгөн орлогыг нэмэгдүүлэх багц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр валютын албан нөөцийг нэмэгдүүлэх

2 ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭГ ЦАР ТАХЛЫН ӨМНӨХ ТҮВШИНД ХҮРГЭЖ НЭМЭГДҮҮЛЭХ

- Экспортын гэрээнүүд болон олборлолтоос экспорт хүртэлх бүх шатны борлуулалтыг **цахимжуулж**, бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх
- Уурхайн ам нөхцөлөөр борлуулахыг зогсоож, **хил хүртэлх нөхцөлөөр** (С зөвшөөрлийг олборлогч ААН олгох) цаашид борлуулах

3 УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОРЛУУЛАЛТ, ТӨРИЙН ӨМЧИТ КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД БОЛГОХ

- Түүхий эдийн борлуулалт, гэрээнүүдийг ил тод болгож далд эдийн засгийг бууруулах
- Уул уурхайн компаниудын **үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг ил тод** болгож хяналтын зөв тогтолцоог бий болгох

4 УУЛ УУРХАЙ, ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШНИЙГ НЭГ ШАТ АХИУЛАХ

- Газрын тос боловсруулах үйлдвэр
- Махны экспортыг үргэлжлүүлж нэмэгдүүлэх
- Арьс шир боловсруулах үйлдвэр ашиглалтад орох хүртэл **түүхий эдийн экспортыг эхлүүлэх**

5 ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙГ ХЯЗГААРЛАЖ БУЙ САЛБАРУУДАД ЛИБЕРАЛЧЛАЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ

- Эрчим хүчний салбарыг үе шаттай либералчлах
- Тээврийн салбарыг (төмөр зам, агаарын тээвэр) либералчлах
- Банкны салбарын реформ, өрсөлдөөнийг дэмжих

6 ХУВИЙН ХЭВШИЛ, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

- Эдийн засгийг төрөлжүүлэх (хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөнгөн үйлдвэрлэл)
- Хөрөнгө оруулалтыг дэмжих
- Төрийн хүнд суртлыг бууруулах (төрийн тусгай зөвшөөрлийн цахим систем г.м)

7 САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ТӨРЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх (ХК-ын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, хариуцлагыг нэмэгдүүлэх)
- Даатгалын тогтолцоог бэхжүүлэх (ил тод, найдвартай даатгалын тогтолцоог бий болгох)

8 БООМТ, ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ

- Нийт боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх
- 2023 онд Гашуунсухайт боомтод төмөр замын чингэлэг терминал
- Ачаа болон зорчигч тээврийн барилга байгууламж байгуулах
- Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминал байгуулах



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА.